

“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ”

ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

**35кВ-н ЦЭНХЭРМАНДАЛ-ЖАРГАЛТХААН
ЦДАШ, 35/10кВ-ын ЖАРГАЛТХААН ДЭД СТАНЦЫН
АЖЛЫН ЗУРГИЙН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалтын дугаар: Т-ХАН[№]19/02

БЗӨБЦТС ТӨХК 2019 он.

НЭГ. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

35кВ-н Цэнхэрмандал-Жаргалтхаан ЦДАШ, 35/10кВ-ын Жаргалтхаан дэд станцын ажлын зургийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг 2019 оны 06 сарын 28-ны өдрийн 14 цагаас өмнө ирүүлэх.

Үнийн саналын нээлтэнд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2019 оны 06-р сарын 28-ны өдрийн 14 цаг 30 минутанд нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Тендерийн баримт бичгийн дагуу холбогдох материалуудыг бүрдүүлж төрийн худалдан авах ажиллагааны цахим системд оруулж бидэнтэй хамтран ажиллахыг хүсье. /Тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нэвтэрч авна уу/

Хаяг: Улаанбаатар хот, Багануур дүүрэг, үйлдвэрийн хэсэг, “БЗӨБЦТС” ТӨХК-ийн конторын байр 202 тоот өрөө.

Утас: 99105839

Факс: 70210167

ХОЁР. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | | |
|---------------------------------------------------------|------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. | Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан цахим хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. |
| | 2.2. | Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, цахим системээр нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. | Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

(а) Үнийн санал.
(б) Нийлүүлэлтийн хуваарь.
(в) Техникийн тодорхойлолт.
(г) Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материал. /ТШӨХ-ийн ТООЗ 1.1-д заасны дагуу/ |
| 4. Тогтмол үнэ | 4.1. | Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгөөр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. | Нийлүүлэх барааны техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. |
| | 5.2. | Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. | Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. |
| | 7.2. | Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ -д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ. |
| | 7.3. | Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. | Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

ГУРАВ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт /Бүрдүүлэх материал/
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн нэг жилийн нийт борлуулалтын орлого тендерийн төсөвт өртгөөс багагүй байна. /Сангийн сайдын 2013 оны тушаалын хавсралт “Цахим тендер зохион байгуулах журмын 1.2 дагуу цахим тендерийн лавлагааг үндэслэнэ/. 2. Одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх шүүхийн төрөлжсөн архив, ШШГЕГ-ын тодорхойлолтуудыг ирүүлнэ. 3. Тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байх, мөн татварын тодорхойлолтыг www.tender.gov.mn цахим сайтын лавлагааг үндэслэнэ 4. Тендерийн баримт бичгийг төрийн худалдан авах ажиллагааны цахим хаягаар ирүүлнэ. 5. Нийлүүлэгч ГТН 4-р заалтыг хүлээн зөвшөөрсөн албан бичиг ирүүлнэ. 6. Ажил хийгдэх хугацаа: 7 хоногоос ихгүй 7. Сүүлийн 3 жилийн ижил төстэй гүйцэтгэсэн ажлын жагсаалт, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, ажил бүр дээр магадлан хяналтаар баталгаажуулсан дүгнэлтийг ирүүлнэ.. /35-110кВ-н хүчдлийн түвшинд хийгдсэн ажлын жил бүрийн мэдээлэл/ 8. Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлж байсан тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно. 9. Хавсралтанд заагдсан боловсон хүчний нөөцтэй байна. / Мэдээллийг маягтын дагуу ирүүлнэ/ <p>Дээрх баримт бичгийг бүрдүүлж ирээгүй тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27.1.3 дугаар зүйлийн шаардлагыг хангаагүй гэж үзэн ирүүлсэн тендерээс татгалзана.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Энэхүү ажлын зураг зурах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn цахим хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа: 2019 оны 06 дугаар сарын 28 өдрийн 14 цаг 00 минутад.</p>
ТӨӨЗ 2.3	<ol style="list-style-type: none"> 1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар. 2. Тусгай зөвшөөрөл ирүүлнэ. 3. Маягтын дагуу үнийн санал ирүүлнэ. 4. НӨАТ төлөгч бол гэрчилгээний хуулбар. (НӨАТ төлөгч биш бол энэ тухай албан тоот ирүүлнэ)
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий байна.</p> <p>Т-ХА№19/02 35кВ-н Цэнхэрмандал-Жаргалтхаан ЦДАШ, 35/10кВ-ын Жаргалтхаан дэд станцын ажлын зургийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг. Багцтай эсэх: Үгүй</p>

ГУРАВ. Боловсон хүчний мэдээлэл

Тендерт оролцогчийн нэр

Тендерт оролцогч нь гэрээний удирдлага болон хэрэгжилтийг хариуцан ажиллахтай холбогдогдох ур чадвар, мэрэгжлийн шаардлагыг хангасан албан тушаалтны нэрсийг албан тушаал тус бүрт дэвшүүлнэ. Нэр дэвшигч бүрийн ажлын туршлагын талаарх мэдээллийг тус тусад нь гаргаж ирүүлнэ.

Д/д	Овог нэр	Албан тушаал		Ажилласан жил	Ажлын туршлага
1		Эрчим хүчний салбарын зөвлөх инженер	1	3-5 жил	Ижил төстэй ажил, төслийн хүрээнд гүйцэтгэгчээр болон гүйцэтгэгчийн багт орж ажиллаж байсан мэдээлэл ирүүлнэ.
2		Цахилгааны инженер	3	3-5 жил	
3		Барилгын инженер	1	3-5 жил	
4		Геодези инженер	1	3-5 жил	

/ Дээрх мэдээллийг нотлох баримт бичгийн хамт ирүүлнэ./

Гурав. АЖЛЫН ДААЛГАВАР

ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН НУТАГТ БАРИГДАХ 35 КВ-ЫН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМ, 35/10 КВ-ЫН ДЭД СТАНЦЫН ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ

1. Зураг төсөл боловсруулах үндэслэл
 - 1.1 “Багануур Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-д
 - 1.2 Эрчим хүчний яамны 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 45/2019/87 тоот техникийн нөхцөл, Эрчим хүчний яамны 2019/06/06 өдрийн 2019/Ц-48 тоот зургийн даалгавар
2. Байршил

Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Баян модот баг, Жаргалтхаан сум 1-р баг
3. Объектийн бүрэлдэхүүн, хүч чад
 - 3.1 Сумдын цахилгаан хангамжийн ЦЭХ-ний хүчдэлийн уналтыг зогсоож, хүчдлийн чанарыг нэмэгдүүлэх, өсөн нэмэгдэж байгаа ЦЭХ-ний хэрэглээ, найдвартай ажиллагааг хангах
 - 3.2 Хэнтий аймгийн Цэнхэрмандал сум, 35/6 кВ-ын “Цэнхэрмандал” дэд станцын 35 кВ систем шинийг өргөтгөх, 35 кВ-ын ЦДАШ-ын гаргалгаа нэмэх
 - 3.3 35 кВ-ын Цэнхэрмандал-Жаргалтхаан чиглэлийн 45 км урттай АС-70/15 маркийн дамжуулагчтай, төмөр бетон тулгууртай ЦДАШ шинээр барих
 - 3.4 Хэнтий аймгийн Жаргалтхаан суманхд 35/10 кВ-ын 1600 кВА хүчин чадалтай дэд станц шинээр барих
 - 3.5 35/6 кВ-ын “Цэнхэрмандал” дэд станцын 35 кВ-ын ил хуваарилах байгууламж /ИХБ/-д систем шинийг 35 кВ-ын 1 гаргалгаар өргөтгөх
 - 3.6 Өргөтгөлөөр хийгдсэн 35 кВ-ын гаргалгаанд олон улсын стандартын шаардлага хангасан гүйдлийн трансформатор, олон улсын ИЕС, КМС стандартын шаардлага хангасан алсын удирдлагатай вакуум таслуур, газардуулгын хугта, бүхий хуурай салгуур, реле хамгаалалт автоматик, хянах хэмжих хэрэгслүүдээр тоноглох
 - 3.7 35 кВ-ын ИХБ-ийг өргөтгөж байгаатай холбогдуулан шин, дамжуулагч утас, изоляторууд болон бусад цахилгаан тоноглолуудыг зураг төслийн шатанд тооцоогоор сонгож, ашиглагч байгууллага “БЗӨБЦТС” ТӨХК-тай зөвшилцөх
 - 3.8 Ачаалал нэмэгдэж байгаатай холбогдуулан, 35 кВ-ын ИХБ-ийн шинийн үндсэн болон бэлтгэл хамгаалалтуудын тооцоог хийж, БЗӨБЦТС болон “ДҮТ” ХХК-тай зөвшилцөх, шаардлагатай тохиолдолд өргөтгөн шинэчлэх
 - 3.9 35кВ-ын ИХБ-ийн өргөтгөлийн зураг төсөл боловсруулах шатанд дэд станцын аянгын хамгаалалт, газардуулгын байгууламжийн тооцоо, хэмжилтийг хийх,
 - 3.10 Шинээр баригдах 35кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам /ЦДАШ/ нь MNS6522:2015 стандартын шаардлага хангасан байх, дамжуулагчийн хөндлөн огтлолыг хэрэглэгчийн ачаалалд тохируулан тооцоогоор сонгох, “БЗӨБЦТС” ТӨХК-тай зөвшилцөх.
 - 3.11 ЦДАШ-ын трассыг зураг төслийн шатанд орон нутгийн болон

- ашиглагч “БЗӨБЦТС” ТӨХК-тай зөвшилцөн сонгох, трассыг бусад шугамын гаргалгаа, трасстай аль болох давхцуулахгүй байх.
- 3.12
- 3.13 35/6 кВ-ын Цэнхэрмандал дэд станцын 35 кВ-ын ИХБ-ийн шин, дамжуулагч утас, изоляторууд болон бусад цахилгаан тоноглолуудыг төслийн шатанд тооцоогоор сонгох, систем шинийн үндсэн болон бэлтгэл хамгаалалтуудын тооцоог хийж шаардлагатай тохиолдолд өргөтгөн шинэчлэх, ашиглагч “БЗӨБЦТС” ТӨХК-тай зөвшилцөх
- 3.14 35 кВ-ын ИХБ-ийг олон улсын стандартын шаардлага хангасан гүйдлийн трансформатор, олон улсын ИЕС стандартын шаардлага хангасан алсын удирдлагатай вакуум таслуур, газардуулгын хутга бүхий хуурай салгуураар тоноглох
- 3.15 Өргөтгөл хийсэн гаргалгаанаас Жаргалтхаан сумын төвд баригдах 35/10 кВ-ын дэд станц хүртэл 35 кВ-ын төмөр бетон ЦДАШ шинээр барих
- 3.16 Шинээр баригдах 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам /ЦДАШ/ нь MNS 6522:2015 стандартын шаардлага хангасан байх, дамжуулагчийн хөндлөн огтлолыг хэрэглэгчийн ачаалалд тохируулан тооцоогоор сонгох
- 3.17 ЦДАШ-ын трассыг зураг төслийн шатанд орон нутгийн болон ашиглагч “БЗӨБЦТС” ТӨХК-тай зөвшилцөн сонгох, трассыг бусад шугамын гаргалгаа, трасстай аль болох давхцуулахгүй байх
- 3.18 ЦДАШ-ын тулгуур нь MNS:4232-2011 стандартын шаардлагыг хангасан байх
- 3.19 Шинээр баригдах 35/10 кВ-ын дэд станц нь MNS 6521:2015 стандартын шаардлагыг хангасан байх
- 3.20 Дэд станцын 35/10 кВ-ын хүчний трансформатор нь MNS GOST 52719:2014 стандарт болон ашиглагч байгууллагын техникийн шаардлагыг хангасан байх
- 3.21 Хүчний трансформатор нь зэс ороомогтой, ачаалал дор автомат тохируулга бүхий РПН-тэй байх, РПН-ны тавилыг автоматаар өөрчлөх төхөөрөмжтэй, алсын удирдлагатай, тогтмол гүйдлийн хэлхээнээс тэжээгддэг, хэвийн хүчдэлийн 1.25%-аас багагүй, 1.6%-аас ихгүй хэмжээтэйгээр өөрчлөх боломжтой байх
- 3.22 35/10 кВ-ын дэд станцын ИХБ нь систем шинтэй байх бөгөөд цаашид өргөтгөл хийх боломжтой байхаар зураг төсөлд тусгах
- 3.23 10 кВ-ын ХБ нь систем шинтэй байх бөгөөд трансформаторын 1 оролттой, дотоод хэрэгцээний трансформаторын-1, хүчдэлийн трансформаторын-1, 3 гаргалгааны ячейктай байх бөгөөд гаргалгааны тоог хэрэглээний ачаалалтай уялдуулан зураг төслийн шатанд сонгох, ашиглагч “БЗӨБЦТС” ТӨХК-тай зөвшилцөх
- 3.24 10 кВ болон 35 кВ -ын гаргалгаа нь олон улсын ИЕС 61850 стандартын шаардлага хангасан гүйдлийн трансформатор, алсын удирдлагатай вакуум таслуур, газардуулгын хутга бүхий хуурай салгуур, цэнэг шавхагч, реле хамгаалалт автоматик, хянах хэмжих хэрэгслүүдээр тоноглох
- 3.25 Ачаалал нэмэгдэж байгаатай холбогдуулан, 10 кВ-ын ХБ-ийн систем шинийн үндсэн болон бэлтгэл хамгаалалтуудыг тооцоог хийх, шаардлагатай тохиолдолд өргөтгөн шинэчлэх боломжтой байхаар зураг төсөлд тусгах
- 3.26 Оруулга, гаргалгын ачаалалд нь тохирсон коэффициент бүхий Монгол Улсын стандарт, шаардлага хангасан хэмжих хэрэгсэл

- суурилуулах, /тоолуурын хэлхээнд 0.2 нарийвчлалтай гүйдлийн трансформатор, ОПН ашиглах/
- 3.27 10 кВ-ын ХБ-нд холбогдох кабель шугам нь MNS 6519:2015 стандартын шаардлагыг хангасан, дамжуулагчийн хөндлөн огтлолыг ачаалалтай нь уялдуулан тооцоогоор сонгох, ашиглагч “БЗӨБЦТС” ТӨХК-тай зөвшилцөх
 - 3.28 10 кВ-ын ХБ-ийн кабелийн туннель, тоноглолд засвар үйлчилгээ хийх зай талбайг норм дүрмийн шаардлагад нийцсэн байхаар зураг төсөлд тусгах
 - 3.29 Реле хамгаалалтын тавил тооцоог эрх бүхий байгууллагаар хийлгэж “ДҮТ” ХХК болон ашиглагч байгууллагаар хянуулж баталгаажуулах
 - 3.30 Ашиглалт, шуурхай үйлчилгээ, харуул хамгаалалтын болон удирдлагын байр барьж шуурхай үйлчилгээний холбоо, ажлын болон аварийн дохиолол, компьютерийн удирдлага бүхий удирдлагын панелиар тоноглох
 - 3.31 Олон Улсын ИЕС 62056 цуврал стандартын шаардлагыг хангасан, Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газрын тохирлын гэрчилгээ бүхий, ашиглагч байгууллагын техникийн шаардлагын хангасан ухаалаг тоолуур сонгох
 - 3.32 Техникийн нөхцөлд дурдсан бусад шаардлагуудыг зураг төсөлд тусгах
4. Барилгын үндсэн бүтээц, материал, бусад шаардлага
 - 4.1. Дэд станцад суурилагдах тоног төхөөрөмж нь Монгол орны цаг уурын нөхцөл, далайн түвшний 1000 м-ээс дээш өндөрлөг, олон улсын ИЕС стандартын шаардлагыг хангасан орчин үеийн дэвшилтэт технологитой байх
 - 4.2. Тооцоогоор сонгогдсон тоног төрөөрөмжүүд нь Монгол Улсын болон Олон Улсын Цахилгаан техникийн хорооноос гаргасан стандартуудыг хангасан байх
 - 4.3. Дэд станцын газардуулга, аянга хамгаалалтын зон, гэрэлтүүлэг нь техник ашиглалтын норм, дүрмийн шаардлагыг хангасан байх
 5. Инженерийн хангамж

Техникийн нөхцөлд дурдсан инженерийн хангамж
 6. Зураг төсөл зохиох үе шат, хугацаа

Нэг үе шаттай, техникийн нөхцлийн хүчинтэй хугацаанд
 7. Цаашид өргөтгөх эсэх

Цаашид өргөтгөх боломжтойгоор зай талбайг тооцож зураг төсөлд тусгах
 8. Барих хугацаа

2019 он
 9. Гүйцэтгэгч байгууллага

“Эрчим хүчний барилга угсралтын тусгай зөвшөөрөл” авсан, эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх
 10. Захиалагч байгууллага

“БЗӨБЦТС” ТӨХК
 11. Зургийн байгууллага

“Эрчим хүчний барилга угсралтын зураг төсөл хийх тусгай зөвшөөрөл” авсан, эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх

12. Онцгой нөхцөл
- 12.1. Зураг төслийг Монгол улсын Цахилгаан байгууламжийн дүрэм, Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн механик ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэмийн дагуу гүйцэтгэх
- 12.2. Зураг төслийг улсын экспертized оруулахын өмнө ашиглагч байгууллага болон холбогдох газруудаар хянуулж, зөвшөөрөл авсан байх
- 12.3. Хүчний болон гэрэлтүүлгийн самбарт давтан газардуулга, галын аюулаас урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг авах

**ОДОО ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ
БАРАА МАТЕРИАЛЫН ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх ижил төстэй гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

ДӨРӨВ. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

2019 оны дүгээр сарын-ны өдөр

БЗӨБЦТС ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Тавинбэх танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу хуанлийн хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|----------------------------------------------------|-------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 /нэг/ жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 2019 оны 12-р сард олгоно. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Ажлын зургийг ТҮАХБ Хэлтэсээс ажлын хэсэг томилон шалгаж үзнэ. Ажлын хэсгийн дүгнэлтээр ажлын зургийг хүлээн авна. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ul style="list-style-type: none">1) Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) Үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;3) Үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ; <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага. |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | Урдчилгаа санхүүжилт олгохгүй. Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг ажлын зураг хүлээн авсан акт болон гэрээг үндэслэн 2019 оны 12-р сард төлнө. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | <p>9.1. Алданги оногдуулах хувь: Гэрээний дүнгийн нэг хоногийн 0,5%</p> <p>Алдангийн нийт дүн: Гэрээний дүнгийн 10%</p> |